



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 5/10

Модот

Асран хамгаалагч, харгалзан дэмжигч
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67.1.1 дэх заалт, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Оюунтөмөрийн Цолмонгоос ирүүлсэн хүсэлтийн дагуу Насанбаяр овогтой Улсболд (УХ11230210), Насанбаярын Есүгэн (СУ14261703), Насанбаярын Солонго (СУ19302588) -ийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр түүний төрсөн эгч болох Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын 4 дүгээр баг Бор-Өндөрийн 1-ын 6 тоот багийн иргэн О.Цолмон (НХ06220303) -ыг тогтоосугай.

2. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг сумын Засаг даргад тайлагнаж байхыг (О.Цолмон)-д үүрэг болгосугай.

3. Сумын Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Н.Улсболд, Н.Есүгэн, Н.Солонго нарт хувийн хэрэг нээж, О.Цолмонтой гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Соёлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ